

ЮРИКА ХХК-ийн Байгаль орчны газраас гаргаж буй магадалгаа нотолгооны лавлагаа,  
тэмдгийг хэрэглэх тухай дүрэм

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү дүрмийг “ЮРИКА” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн Байгаль орчны газрын үйл ажиллагааны нэг хэсэг болох Магадалгаа нотолгооны үйл ажиллагааны магадалгаа нотолгооны лавлагаа, тэмдгийг хэрэглэх харилцааг зохицуулахаар Монгол Улсад батлав.
- 1.2. Энэхүү дүрмийн хамрах хүрээ нь магадалгаа нотолгооны мэдэгдлийн өгөгдөл болон мэдээллийн лавлагааны үйл ажиллагаад хамаарна.

### ХОЁР. МАГАДАЛГАА НОТОЛГООНЫ ЛАВЛАГАА, ТЭМДГИЙГ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ

- 2.1. Энэхүү дүрмийн зорилго нь тэмдгийг ашиглагч талын эрх, тэмдгийг хэрэгжүүлэгч талын эрх, ашиглах эрхийг цуцлах, дуу дурс бичлэг болон мультимедиа болон тэмдгийг ашиглах дүрэм журам болон хяналтыг тодорхойлоход оршино.
- 2.2. Энэхүү эшлэл, тэмдгийг зөвхөн магадалаа нотолгооны мэдүүлэгтэй холбогдуулан ашиглах ба бүтээгдэхүүний магадалгаа нотолгоо хийсэн гэж үзэхгүй.
- 2.3. Энэхүү тэмдэг нь бизнесийн харилцаанд “ЮРИКА” ХХК-ийн Байгаль орчны газрын гүйцэтгэсэн олон улсын менежментийн тогтолцооны стандартын шаардлага хангасан байгууллагын тодорхойлолт болно.
- 2.4. Мэдэгдэлийн дугаарыг тэмдгийн дараа байрлуулж болно.
- 2.5. Магадалгаа нотолгооны үйл ажиллагааны хамрах хүрээг тухайн байгууллагын бүх байршил болон үйл ажиллагааг бүхэлд нь эсвэл талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр хэсэгчлэн тодорхойлох боломжтой бөгөөд хэсэгчлэн тодорхойлсон тохиодолд зөвхөн хамрах хүрээнд багтсан барилга байгууламж болон үйл ажиллагаанд магадалгаа нотолгооны тэмдэг, мэдэгдэл олгоно.
- 2.6. Магадалгаа нотолгооны мэдээллийн мэдэгдэл, санал, тайлан, тэмдэг зорилтот хэрэглэгч, гуравдагч хэрэглэгчийг төөрөлдүүлэхүйц байдлаар хэрэглэхгүй.
- 2.7. Магадалгаа нотолгооны мэдээллийн мэдэгдэл, санал, тайлан, тэмдэг эсвэл шошгыг байгууллагын нэр хундэд хохирол учруулахгүй байхыг талуудын харилцан тохиролцсон Хүлэмжийн хийн мэдэгдэлд магадалгаа нотолгоо хийх, мэдэгдэл эзэмшүүлэх тухай гэрээ /URECA-VVP-03-V2-F-05/-ний үүргийг биелүүлнэ.
- 2.8. Тэмдгийг хэрэглэхдээ магадалгаа нотолгооны үйл ажиллагааны хүрээнд тодорхойлсон хүлэмжийн хийн хэмжээ, холбогдох огноо, хамрах хүрээ, мэдэгдэлийн дугаарыг заавал оруулна.
- 2.9. Хүлэмжийн хийн мэдэгдэлд магадалгаа нотолгоо хийх, мэдэгдэл эзэмшүүлэх тухай гэрээ /URECA-VVP-03-V2-F-05/-д заасны дагуу үйлчлүүлэгч аливаа санал, баримттай илрүүлгийн тайланг нийтлэхдээ бүхэлд нь мэдээллэнэ.
- 2.10. “ЮРИКА” ХХК-д ирүүлсэн буюу Байгаль орчны газарт мэдэгдсэн санал, баримттай илрүүлгийн тайлангаас өөр, ялгаатай буюу өөрчлөлт орсон тайланг гуравдагч этгээд, зорилтот хэрэглэгч, олон нийт гэх мэт ямарваа нэгэн талд мэдээллэсэн нь илэрвэл үйлчлүүлэгч байгууллагын магадалгаа нотолгооны мэдэгдлийн тэмдгийг тутгэлзүүлэх,

доголдлыг арилгуулах цаашлаад Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон талуудын хооронд байгуулсан гэрээнд үндэслэн шийдвэрлэнэ.

2.11. “ЮРИКА” ХХК-ийн Байгаль орчны газар магадалгаа хийсэн тохиолдолд доорх тэмдгийг ашиглана.



Мэдэгдэлийн дугаар	xx
Хамрах хүрээ	xx
Ялгаруулсан хүлэмжийн хийн хэмжээ	xx
Суурь жил	xx

- a.
- b. Хэмжээ: 1x1 хэмжээг алдагдуулахгүй ашиглана.
- c. Энэхүү дүрэмд тусгасан тэмдгийн өнгийг өөрчлөхгүй байх.
- d. Тэмдгийг дангаар нь хэрэглэхгүй бөгөөд тэмдэг, хамрах хүрээ, ялгаруулсан хүлэмжийн хийн хэмжээ, суурь жилийн мэдээлэл нь тэмдгийн салшгүй нэг хэсэг байна.

2.12. “ЮРИКА” ХХК-ийн Байгаль орчны газар нотолгоо хийсэн тохиолдолд доорх тэмдгийг ашиглана.



Мэдэгдэлийн дугаар	xx
Хамрах хүрээ	xx
Ялгаруулсан хүлэмжийн хийн хэмжээ	xx
Суурь жил	xx

- a.
- b. Хэмжээ: 1x1 хэмжээг алдагдуулахгүй ашиглана.
- c. Энэхүү дүрэмд тусгасан тэмдгийн өнгийг өөрчлөхгүй байх.
- d. Тэмдгийг дангаар нь хэрэглэхгүй бөгөөд тэмдэг, хамрах хүрээ, ялгаруулсан хүлэмжийн хийн хэмжээ, суурь жилийн мэдээлэл нь тэмдгийн салшгүй нэг хэсэг байна.

2.13. Хүлэмжийн хийн мэдэгдэлд магадалгаа нотолгооны үйл ажиллагаа хийсэн тухай лавлагаа, тэмдгийг дараах тохиолдолд ашиглахгүй:

- a. Мэдэгдэлийг буруугаар ашиглах;
- b. Хэрэв мэдэгдэлийг буруугаар ашигласан нь илэрсэн тохиолдолд эхний байдлаар запруулах арга хэмжээ авах бөгөөд Тэмдэг эзэмшигч тал бичгээр мэдэгдэх ба тэмдэг хэрэглэгч тал ажлын 5 хоногийн дотор запруулна.
- c. Запруулсан тухай нотлох баримтыг “ЮРИКА” ХХК-д бичгээр мэдэгдэнэ.
- d. Хэрэв хоёр болон түүнээс дээш удаа санаатай болон санамсар болгоомжүй үйлдэл, илтэд болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүй байдлаар мэдэгдэл эсхүл тэмдгийг буруугаар ашигласан тохиолдолд тэмдэг хэрэглэгч талын тэмдэг хэрэглэх эрхийг тутгэлзүүлэх үндэслэл болно.

е. Санаатайгаар гүйвуулж ашигласан, залруулах арга хэмжээний хугацаанд залруулаагүй тохиолдолд тэмдэг хэрэглэгч талын тэмдэг хэрэглэх эрхийг түтгэлзүүлэх үндэслэл болно.

## ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Тэмдгийг хэрэглэгч нь Магадалгаа нотолгооны үйл ажиллагаа нь бүхэлдээ эсвэл тодорхой байршилд, хамрах хүрээнд багтсан үйл ажиллагаа нь “ЮРИКА” ХХК-ийн Байгаль орчны газраар магадалгаа нотолгво хийлгэсэн байгууллага.

3.2. Тэмдгийг хэрэглэгч талын эрх нь байгууллагад:

- “ЮРИКА” ХХК –аас авсан хүчинтэй мэдэгдэл байх
- Гэрээгээр болон хуулиар баталгаажсан байх
- Тэмдэгт нь “ЮРИКА” ХХК-ийн өмч бөгөөд гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
- Энэхүү дүрмийг чанд дагаж мөрдөх үүрэгтэй

## ДӨРӨВ. БУСАД ЗҮЙЛ

4.1. Энэхүү дүрмийг батлах, хүчин төгөлдөр болох, хэрэгжүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, дуусгавар болгоход Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг баримтлана.

4.2. Энэхүү дүрэм нь “ЮРИКА” ХХК-ийн Гүйцэтгэх захирал болон Байгаль орчин хариуцсан захирал нар гарын үсэг зурж, баталгуужуулснаар хүчин төгөлдөрт тооцогдоно.

Энэхүү дүрмийг 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдөр батлав.

“ЮРИКА” ХХК-ийн Гүйцэтгэх захирал

“ЮРИКА” ХХК-ийн Байгаль орчин хариуцсан захирал

